

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.2.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбарыг боловсруулах, хөгжүүлэлтийг хийх, бэлэн байдлыг хангуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/ Баримт бичгийн тоо Арга хэмжээний тоо Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" батлагдсан. ЗГҮАХ-т туссан 149 хөгжлийн төсөл. Нийт 17	УХОХ-ийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан байна. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга	УХОХ-ийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг авсан. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан. Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр	100%	95%	

	ажлыг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.			тогтворжуулах гэрчилгээ олгож, 5 хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.	хэмжээг авсан байна. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна.	байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна.			
3.2.1	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлж, эрэмбэлнэ.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" батлагдсан.	УХОХ-ийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. /100 хувь/	УХОХ-ийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. /100 хувь/	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хүрээнд "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулсан. Энэ хүрээнд Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 сарын 04-ны өдрийн 01/885 дугаартай албан бичгээр Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санал авахаар бүх сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт хүргүүлсэн. Улсын хөрөнгө оруулалтын	100%	100%

						<p>удирдлагын цахим систем /www.invest.gov.mn/-ээр дамжуулан УХОХ-т тусгах саналыг 2025 оны 10 дугаар сарын хүртэл саналыг хүлээн авч, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалын дагуу төслүүдийг үнэлж эрэмбэлэн боловсруулсан. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох хавсралтуудыг боловсруулж Бүх сайд, Улсын Их Хуралд ажаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага нараас санал авахаар Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 10 сарын 01-ний өдрийн 01/2707 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. 2025 оны 10 сарын 15-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Улмаар 2025 оны 10 сарын 21 өдрийн 01/2871 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсыг хөгжүүлэх таван</p>		
--	--	--	--	--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

							жилийн үндсэн чиглэл 2025 оны 11 сарын 28-ний өдрийн Улсын Их хурлын чуулганаар хэлэлцэгдэж батлагдсан. Нийт улсын хөгжлийг хурдасгахад шаардагдах дэд бүтэц, нийгмийн хэрэгцээг хангах, салбарын бодлогыг эрчимжүүлэх чиглэлийн 87 төсөл батлагдсан.		
3.2.2	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх саналыг хүлээн авч, эрэмбэлэх тодорхойлох ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардлаар	Баримт бичгийн тоо	-	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан байна. /Баримт бичгийн тоо 1/	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан байна. /Баримт бичгийн	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуульд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын багцад "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/" төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүний хүрээнд бүх ТЭЗ болон 21 аймгийн ЗД нараас санал авсан бөгөөд 900 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх төсөл, арга хэмжээний мэдээллийг авч, нэгтгэсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн төслийн саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал, эдийн засгийн	100%	100%

2024

						тоо 1/	<p>үр ашиг, нийгмийн ач холбогдол, санхүүжилтийн эх үүсвэрийг хувийн хэвшлээр болон бусад эх үүсвэрээс санхүүжих боломж зэрэг үндсэн шалгуураас гадна бусад төсөвт өртөг, урсгал зардал нэмэгдүүлэх эсэх, газрын асуудлыг харгалзан үнэлж эрэмбэлэн, сонгогдсон төслүүдийн жагсаалтыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/32, А/44, А/58 дугаар тушаалаар эцэслэн баталсан. Жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт тухай бүр албан бичгээр тус тус хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны газар жагсаалтаар батлагдсан төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж 19 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан.</p>		
3.2.3	Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Арга хэмжээний тоо	ЗГҮАХ-т туссан 149 хөгжлийн төсөл.	Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж,	Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж,	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн мөрөөр хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний дагуу бодлогын баримт бичигт туссан тэргүүлэх төслүүдийг	100%	100%

	арга хэмжээг авна.				хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг авсан байна. /Арга хэмжээний тоо 2/	хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг авсан байна. /Арга хэмжээний тоо 2/	үнэлж, эрэмбэлсний үр дүнд хэрэгжилтийг хангуулахаар 2025 оны 07 сарын 23-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж "Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 28 дугаар тогтоолыг боловсруулж, батлуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамны 2025.08.14-ний өдрийн 02/2170, 02/2187 дугаар албан бичгээр нийт төрийн захиргааны төв байгууллага болон Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хандаж, medgov.work төслийн цахим маягтаар дамжуулан хөгжлийн төсөл, арга хэмжээний талаарх цогц мэдээллийг авч нэгтгэн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан нийт 149 хөгжлийн төслийг хэрэгжих боломжоор нь жагсаалт гаргаж, үнэлж эрэмбэлэн 2025 оны 10 сарын 08-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж "Хөгжлийн төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний		
--	--------------------	--	--	--	---------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

27

							тухай" 122 дугаар тогтоолыг боловсруулж албажуулсан. Тус тогтоолоор 1/Тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 81 төсөл, 2/Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 22 төсөл, 3/Бэлэн байдлыг хангах шаардлагатай 11 төслийг тодорхойлж хэрэгжилтийг эрчимжүүлэх, хариуцагчийг тодорхой болгох чиглэлээр ажилласан.		
3.2.4	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	Нийт 17 тогтворжуулах гэрчилгээ олгож, 5 хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. /100 хувь/	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. /100 хувь/	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг судлан хэлэлцэж, эцэслэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ерөнхий сайдын 2024 оны 27 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 140 дугаар тушаалын хавсралтаар байгуулагдсан Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажлын дэд хэсэгт оролцож, гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулан ажилласан. Тус Монгол Улсын Засгийн газар	100%	90%

							болон Орано Майнинг компани хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгуулах хүсэлтэд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байнгын болон байнгын бус нийт 17 гишүүнтэй байгуулахаар төлөвлөж байгаа ба зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох асуудлаар тухай бүр хүсэлт гаргасан байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл өгсөн.		
3.2.5	Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавина.	Үйл ажиллаг ааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	-	Тухай бүр шаардлага тай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Тухай бүр шаардлаг атай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Хуулийн төсөлтэй холбоотойгоор ХОБГ-аас дараах ажлыг хийж	100%	90%

						<p>гүйцэтгэсэн. 1/Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.02.24-ний өдрийн өдрийн 01/532 дугаар албан бичгээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т зааснаар "Монгол Улсын Засгийн газрын гишүүд"-аас 30 хоногийн хугацаанд хуулийн төсөлд санал авах ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>2/Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, 20.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авсан.</p> <p>3/Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 38 дугаар зүйлийн 38.4-т заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны албан ёсны цахим хуудас, Монгол Улсын Хөгжлийн банкны цахим хуудас болон Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тус тус</p>	
--	--	--	--	--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--


							2025.02.24-ний өдрөөс 2025.04.25-ны өдрийг хүртэлх 60 (жар) хоногийн хугацаанд байршуулж, олон нийтээс санал авах ажиллагааг зохион байгуулсан. 4/Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.6.2-т тус тус заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2025 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдөр МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулсан. 5/Хуулийн төслийг өргөн мэдүүлэх албан бичгийг 2025.05.30-ны өдрийн 01/1530 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн.		
3.2.6	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг	Үйл ажиллагааны зардлаар	Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/	-	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан	Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд	Ерөнхий сайдын "Шинэ итгэл, эрс шинэтгэл" танилцуулгын Монгол Улсад 2026-2030 онд бий болох бүтээн байгуулалтын төслүүдийн үр дүн, хөрөнгө оруулалтын мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн. ЗГҮАХ-т туссан 149 төслийг ач холбогдол, хэрэгжих боломж гэсэн үндсэн 2 шалгуур, 14 дэд шалгуураар үнэлж эрэмбэлсэн. 2025 оны 10 сарын 08-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд	100%	90%

	хангана.				байна. /Ажлын хэсгийн тоо 3-аас доошгүй/	ажилласа н байна. /Ажлын хэсгийн тоо 3-аас доошгүй/	<p>танилцуулж "Хөгжлийн төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 122 дугаар тогтоолыг боловсруулж батлуулсан ба тус тогтоолоор 1/Тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 81 төсөл, 2/Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 22 төсөл, 3/Бэлэн байдлыг хангах шаардлагатай 11 төслийг тодорхойлж хэрэгжилтийг эрчимжүүлэх, хариуцагчийг тодорхой болгох чиглэлээр ажилласан. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын ахалж буй Багануурын уурхайг түшиглэсэн "Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор"-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг, Дархан, Сэлэнгийн бүсийн "Үйлдвэр технологийн парк"-ийн хөгжлийн төлөвлөгөө, "Дархан төмөрлөгийн үйлдвэр"-ийг өргөтгөх болон Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлуулж, хөрөнгө оруулагч,</p>		
--	----------	--	--	--	------------------------------------------------------	--------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

							гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулсан.		
--	--	--	--	--	--	--	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

Үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)



(Handwritten signature)
.....
(гарын үсэг)

/М.Батхүү/

2025.12.15
(огноо)

Тайлагнасан:

Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын
удирдлагын хэлтсийн дарга
(албан тушаал)

(Handwritten signature)
.....
(гарын үсэг)

/Б.Төгөлдөр/

2025.12.15
(огноо)